



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ
**ШУДАРГА ӨРСӨЛДӨӨН,
ХЭРЭГЛЭГЧИЙН ТӨЛӨӨ ГАЗАР**

Засгийн газрын XII байр, Барилгачдын талбай 13,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15170
Утас: 26 26 53, Факс: (976-11) 32 00 41,
Цахим шуудан: contact@afccp.gov.mn,
Цахим хуудас: www.afccp.gov.mn

2024. 03. 25 № 01/429

танай _____-ны № _____-т

**Тендерийн гомдол хянасан
тухай**

Танай эмнэлгээс 2024 оны 02 дугаар сарын 16-ны өдөр зарласан “Багаж техник хэрэгсэл худалдан авах” ЭНЭҮТ2/20240102009 дугаартай тендерийн баримт бичигт холбогдох гомдлыг “Биомэд трейд” ХХК-аас тус газарт ирүүлснийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 58 дугаар зүйлд заасны дагуу хянан үзлээ.

Тендерийн баримт бичигт Нярайн хяналтын монитор, Хүүхдийн срар, Автомат тариурын шахуурга, Хөхний хавдрын эрт үед нь илрүүлэгч AI буюу хиймэл оюун ухааны программ хангамж, Хүүхдийн унтуулгын аппарат зэрэг хэрэгслүүдийг хамтад нь багцалсан байна.

Захиалагчаас ирүүлсэн 2024 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн 02/145 дугаартай албан бичгээр ирүүлсэн тендерийн баримт бичгийн болон тус тендерийн үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга, бөгөөд тус эмнэлгийн тоног төхөөрөмжийн тасгийн эрхлэгч Б.Буяннэмэхийн 2024 оны 03 дугаар сарын 21-ний өдөр бичгээр тус газарт өгсөн тайлбараас үзэхэд дээрх хэрэгслүүд нь эрчимт эмчилгээ, хагалгаа, дүрс оношилгоонд аль ч тохиолдолд ашиглагддаг байх тул зориулалтын хувьд тусад нь багцлах шаардлагагүй бөгөөд оролцогчдын өрсөлдөөнийг хязгаарласан гэх үндэслэл тогтоогдохгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.5 дахь заалтад “Захиалагч өрсөлдөөнийг дэмжих зорилгоор бараа, ажил, үйлчилгээг зориулалт, нэр төрөл, газар зүйн байрлалыг харгалзан нэг төрлийн болон ижил төстэй байдлаар багцалж болно” гэж заасныг зөрчсөн гэж үзэх үндэслэлгүй байна.

Иймд “Багаж техник хэрэгсэл худалдан авах” ЭНЭҮТ2/20240102009 дугаартай тендер шалгаруулалтыг үргэлжлүүлэн явуулна уу

ДАРГА



Б.БИЛГҮҮН

0001234